

Үйлдвэрлэлийн Технологи Дизайны Сургуулийн шинэ номын мэдээ



Он: 2009, Хот: 2009
Хуудас: 152
ISBN: 978-99929-66-74-2

Бизнес төсөл боловсруулах аргачилсан зөвлөмж

Зохиогч: П.Одмаа
Хянан тохиолдуулсан: С.Төгс

Шинэ санаа, шилдэг бүтээлээ бодит биелэл болгох, түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр хайж олох, хөрөнгө оруулагчдыг татахын тулд тооцоо судалгаа хийж, төсөл боловсруулах зайлшгүй шаардлагатай мэдээллийг энэхүү зөвлөмжинд оруулсан болно.



Он: 2009
Хуудас: 289

Бизнесийн удирдлагын онол, практик, даалгавар тест, бодлого нөхцөл

Зохиогч: Б.Цэрэндорж

Гарын авлага нь Бизнесийн удирдлага, бизнесийн практик даалгавар, санхүүгийн бодлого, үйлдвэрийн газрын эдийн засгийн тест, бодлого нөхцөл гэсэн 4 хэсэгтэй. Хэсэг бүрт холбогдох асуудлыг зохио тайлбартайгаар дэлгэрэнгүй бичиж, хариуг хавсаргасан болно.



Он: 2008, Хот: USA
Хуудас: 680
ISBN: 978-0-47175527-2

Global marketing management

Зохиогч: M.Kotabe, K.Helsen

Тус сурах бичигт сүүлийн зуунд даяарчлагдаж байгаа зах зээлийн эдийн засгийг хэрхэн удирдан зохион байгуулах, түүний онол, судлагдах зүйл, зах зээлийг хэрхэн удирдах тухай онолын мэдлэгүүдийг өгүүлсэн.

Бүтээлийн түүвэр: Сэтгэл зовнихоо больж амар жимэр
аж төрөх ур чадвар
Өөртөө итгэж бусдыг дагуулах ур чадвар

Нөхдөө өөртөө татаж хүмүүст нөлөөлөх ёсон

Зохиогч: Дейл Карнеги
Орчуулагч: Д. Баасанжав

Миссури муж улсын хэний ч үл мэдэх нэгэн фермээр явсан Дейл Карнеги хүн төрөлхтний эгээхэн хэрэгцээг хангах аргыг олсон учраас дэлхий дахинаа алдаршсан билээ. Тэрээр бүтээлдээ хүмүүст хандах үндсэн зарчим, амьдралаа жаргалтай болгох арга барилууд, олны өмнө ярих урьдчилсан нөхцөлүүд, сэтгэл зовоосон асуудлыг шийдвэрлэхэд тус болохуйц зөвлөмжүүд зэрэг асуудлын талаар өгүүлжээ.

CV хэрхэн бичих вэ?: Сайн CV амжилт авчирна

Зохиогч: Ж.Бат-Ирээдүй, Б.Номунзул

Өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан гадаад оронд ажил мэдүүлэх, өргөдөл гаргахад тусгай анкет буюу CV (Curriculum Vitae) өгөх зайлшгүй шаардлага гарч байна. Зөв CV-тэй байх нь ажил олох хамгийн том боломж учир энэ гарын авлага танд хэрхэн CV бичих талаар дэлгэрэнгүй өгүүлнэ.

Монгол Ардын хээ угалз Д.1.

Хянан тохиолдуулсан: Л.Чуваамид

Хүн төрөлхтний нүдийг хужирлан сэтгэлийг хөдөлгөдөг эрхэм урлагийн нэг болох хээ угалзны хэмжих зураас, гарал үүсэл, бүтэц, зохиомж, утга бэлгэдэл, өнгийн нэгдэл, урлах арга, өнгө үзэмжийн нарийн зүй тогтоцын өвөрмөц түүхэн замналын талаар өгүүлнэ. 8 бүлэгтэй.



Он: 2008-2009, Хот: УБ
Цуврал: 1-3
ISBN 978-99929-0-830-0
ISBN: 978-99929-0-829-7



Он: 2007, Хот: УБ
Хуудас: 78



Он: 2009, Хот: Улаанбаатар
Хуудас: 238
ISBN: 99929-0-656-1



Монгол дархны урлаг

Зохиогч: Л.Батчулуун

Хянан тохиолдуулсан: Х.Маам

Энэхүү бүтээлд дархны урлагийн гарал, төмөрлөгөөр урлах эрдэм, дархны урлагийн технологи, гагнуур, монгол цутгуурын урлаг, сийлбэр, эрдэнэсээр урлах ухаан, хээ угалз, монгол дархны багаж зэмсэг зэрэг олон сонирхолтой бүлгүүдийг хамруулжээ.

Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Бэмби сан
Хуудас: 1004
ISBN: 978-99929-78-61-9



Ноос, ноолуур, ээрмэл, сүлжмэл, нэхмэл, эсгий бүтээгдэхүүний стандартын эмхэтгэл: Монгол улсын стандарт

Энэ стандартыг ШУТИС-ийн ҮТДС-ийн нэхмэлийн хүрээлэнгийн Ноос, ноолуурын сорилтын төв, МААЭШХ-тэй хамтран боловсруулсан бөгөөд 61 нэр төрлийн стандарт хамрагджээ.

Он: 2009, **Хот:** УБ
Хуудас: 406



Арьс шир, үслэгийн үйлдвэрлэлийн экологийн асуудал

Зохиогч: С.Дашбал, А.Гантөмөр

Хянан тохиолдуулсан: Д.Урнаа

Байгалийн эргэлтийн тухай ойлголт, байгалийн нөөцийг ашигласнаас гарч байгаа хор хөнөөл нь эргээд хүрээлэн байгаа орчинд сөргөөр нөлөөлж байгаа байдал, арьс ширний үйлдвэрээс гарах хатуу хаягдлыг боловсруулж ашиглах арга замууд, цэвэрлэгээний арга технологи, гадаад орнуудын ашиглаж буй хор багатай химийн материал, дэвшилттэй машин тоног төхөөрөмжийн танилцуулгыг оруулжээ.

Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Судар мөнх ХХК.,
Хуудас: 166
ISBN: 978-99929-1-561-7

Гутал, оёдлын үйлдвэрийн бэлтгэх цехийн тоног төхөөрөмж

Зохиогч: Ж.Нарангэрэл

Орчуулагч: Ж.Авдай

Энэхүү сурах бичигт машин тоног төхөөрөмж гэж чухам юу болох түүнийг зориулалтаас нь хамааруулан хэрхэн ангилах, машин тоног төхөөрөмжийн хөгжлийн чиг хандлага, эсгүүрийн даавуу болон арьс ширэн материалыг хүлээн авах, эсгүүр хийх аргууд, эсгүүрийн суурь машины бүтэц, ажиллах зарчим, хийх ширээнүүдийн төрөл онцлогийн талаар дэлгэрэнгүй бичжээ.



Он: 2009, **Хот:** УБ
Хуудас: 159
ISBN: 978-99929-66-81-5

Эсгий урлал

Зохиогч: Б.Эрдэнэцэцэг

Хянан тохиолдуулсан: Д.Энхтуяа

Гэрийн нөхцөлд ноос угаах, самнах, будаж боловсруулах болон өргөн хэрэглээний эсгий эдлэл хийх арга, зарчим, үлгэр хэв гаргаж өөрчлөх болон эсгий гоёл, тоглоом хийх тухай номд өгүүлжээ.




Он: 2006, **Хот:** Улаанбаатар
Хуудас: 44
ISBN: 99929-11-25-5

Хувцасны зохиомж

Зохиогч: Г.Чулуунаа

Хянан тохиолдуулсан: Б.Мөнхцэцэг

Энэхүү номонд хувцасны хөгжлийн түүх, хувцасны хэлбэрийн анхдагч элементүүд, зохиомжийн үндсэн аргууд, загвар зохион бүтээлт, хүний биеийн хэлбэр, харьцааг схемээр зурах талаар тусгажээ.



Он: 2009, **Хот:** УБ
Хэвлэлийн газар: Адмон
Хуудас: 127
ISBN: 99929-0-779-7

Үйлдвэрлэлийн Технологи Дизайны Сургуулийн шинэ номын мэдээ



Он: 2009, **Хот:** Улаанбаатар
Хэвлэлийн газар: Өнгөт хэвлэл архим
Хуудас: 129
ISBN: 0-85950-404-2
ISBN: 978-99929-52-73-3

Эмэгтэй хувцасны зохион бүтээлт, загварчилгаа : Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлд зориулсан сурах бичиг

Орчуулсан: англ. хэл. орч. М.Баяр, Д.Ариунболор, Б.Оюэн- Эрдэнэ

Хянан тохиолдуулсан: С.Цэцгээ

Сурах бичигт цамц, жакет, пальто, даашинз, өмд зэрэг гадуур хувцас болон дотуур хувцасны суурь үлгэрийг байгуулах, дизайны шийдэлд нийцүүлэн загварчлах загварчилгааны олон төрлийн арга, техникийг багтаасан.



Он: 2008
Хуудас: 120

Винцент ВАН-ГОГ Амьдрал, уран бүтээл, захидлууд

Зохиогч: Б.Нацагдорж

Хорвоод 37 наслахдаа бүтэн хоолтой орой, жаргалтай дүүрэн өдрүүд бараг байгаагүй зүдгүүрт амьдрал туулсан Голландын нэгэн даруухан иргэн зураач байсан түүний амьдрал болон уран бүтээлийн талаар дэлгэрэнгүй уг номоос танилцаж болно. Түүний бүтээлүүдийг өнөөдөр дэлхий даяараа таньж бишрэн магтацаж, уран зургийн үнэлгээний үнэ цэнийн дээд хэмжээг соёлт хүн төрөлхтөнд үзүүлж, бичсэн захидлуудыг нь урлаг судлаачид, зохиолчид, сэтгэл судлаачид, тэр бүү хэл хэл шинжээчид бүхий л талаас нь шинжлэн олон тооны өгүүлэл, роман, кино бичиж байгаа тухай унших болно.



Он: 2009
Хуудас: 66

Уран зургийн материалууд

Зохиогч: Б.Нацагдорж, Ц.Бадармаа

Энэхүү гарын авлагад уран зургийн материалууд болох зотон, тосон будаг, цардас, өнгөлөгч, бэхжүүлэгч, бийр, тушь, харандаа, бистр, гуашь, пастель, мастихин талаар өгүүлээд зогсохгүй уран бүтээлээ туурвиж буй хүмүүст зориулагдсан болно.

**Иллюстрированный словарь русского искусства:
Энциклопедия мирового искусства**

Хянан тохиолдуулсан: Н.А.Борисовская

Оросын урлагийн тухай энэхүү зурагт толь бичиг нь орчин үеийн дүрслэх урлагийн бүтээл дотроос хамгийн дэлгэрэнгүй лавлах бөгөөд түүнд Киевийн Орос орноос XX зууны эцэс хүртэлх үеийн он дараалсан баримтыг өгүүлж уран барилга, уран зураг, уран баримал, график дизайн гэх мэт өргөн хүрээний сэдвүүдийг хамарсан. Үүний зэрэгцээ янз бүрийн мастеруудын тухай болон урлагийн төрөл бүрийн жанар, чиглэлийг өгүүлсэн дүгнэн бичсэн өгүүллүүдийг багтаасан.

Органик хими: Сурах бичиг

Зохиогч: Б.Бямбагар


Хянан тохиолдуулсан: М.Наранцэцэг

Их дээд сургуулийн уг сурах бичигт органик бодисын химийн ба физикийн шинж чанар нь тэдгээрийн орон зайн байгуулалт, атомуудын харилцан нөлөөллөөс ихээхэн хамаардгийг харгалзан стереоизомер, конфигурацийн изомер буюу энантиомерыг дүрслэх аргууд, тэдгээрийн D, L, ба R, S нэршил, абсолют конфигурацийг тодорхойлох арга, динамик стереохими болон электроны эффект, резонанс, урвалын төрлүүд, тэдгээрийн механизм, явагдах чиглэлийн тухай ойлголтуудыг түлхүү оруулсан.

Машины эд анги: Сурах бичиг

Зохиогч: Г.Чимэд-Очир, Т.Намнан, П.Өлзийсайхан, Д.Ганбат

Энэхүү номонд машины байгууламжийн механикийн онолын бүрэлдэхүүн хэсэг болох машины эд анги (machine de sign; детали машин) хичээлийн үндсэн агуулгыг хамран оруулав. Эдгээрт механик дамжуулга (цилиндр, конус,могой, оосор,гинж), гол, тэнхлэг, холхивч, холбовч, холбоосны хэрэглээний түүх, материал, бат бэхийн тооцооны онолын үндэс, инженерийн тооцооны программ хангамжийг хэрхэн ашиглах талаар тайлбарлан оруулсан болно. Сурах бичгийг их дээд сургууль, коллежид механик инженер, инженер технологийн чиглэлээр суралцаж байгаа оюутан болон инженер техникийн ажилтнуудад зориулсан.



Он: 2001, **Хот:** Москва
Хэвлэлийн газар: Белый город
Хуудас: 551
ISBN: 5-7793-0372-X



Он: 2010, **Хуудас:** 502
ISBN: 978-99929-50-05-6



Он: 2009
Хуудас: 330
ISBN: 978-99929-4-437-4

Үйлдвэрлэлийн Технологи Дизайны Сургуулийн шинэ номын мэдээ



Он: 2009
Хуудас: 119

Монголын түүх: Гарын авлага - сорил

Зохиогч: Д.Сэрдарам, Ц.Цэрэн, Ю.Болдбаатар

Энэхүү гарын авлага нь оюутан суралцагчдын хичээлээр олсон мэдлэгийг бататгах, явцын ба улирлын шалгалтанд бэлтгэхэд хэрэглэгдэхүүн болох, бие даалтын ажилд ашиглахад зориулагдсан болно.



Он: 2009, Хот: Улаанбаатар
Хэвлэлийн газар: Стартлайн ХХК
Хуудас: 90
ISBN: 978-99929-931-5-4

Барилгын инженерийн зураг төслийн үндэс

Зохиогч: Н.Нямжав

Хянан тохиолдуулсан: Д.Алтансүх

Барилгын зураг төслийн ажлыг гүйцэтгэхэд тавигдах үндсэн шаардлага, барилгын зураг төсөл, архитектурын шийдлийн ажлын зургууд зэрэг барилгын үйлдвэрлэлийн зураг төслийг гаргахад холбогдох материалын талаар тусгажээ.



Он: 2006, Хот: Улаанбаатар
Хэвлэлийн газар: Адмон
Хуудас: 252
ISBN: 99929-0-691 - X

Монгол инженерийн ухаан

Эмхэтгэсэн: Д.Батцэцэг

Хянан тохиолдуулсан: Д.Содномдорж

Монголын инженерийн ухааны үндэсний академиас зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд тавигдсан илтгэлүүдийг багтаасан.

Инженерийн ухаан – эх орны хөгжил

Эмхэтгэсэн : Д.Батцэцэг

Хянан тохиолдуулсан: Д.Содномдорж

Энэхүү номонд Монголын инженерийн ухааны үндэсний Академи үүсч байгуулагдсаны 10 жилийн ойд зориулагдсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэлийг оруулав.



Он: 2007, **Хот:** Улаанбаатар
Хэвлэлийн газар:Адмон
Хуудас: 247
ISBN: 99929-0-404-6

Монгол инженерүүдийн бүтээлч сэтгэлгээний хөгжил

Эмхэтгэсэн : Д. Батцэцэг

Хянан тохиолдуулсан: Д. Содномдорж

Монголын инженерийн ухааны үндэсний академийн товч танилцуулга, гишүүдийн товч намтар, бүтээлийн товчоон болон бүтээлүүдийг эмхтгэн оруулсан.



Он: 2009, **Хот:** Улаанбаатар
Хэвлэлийн газар:Адмон
Хуудас: 231
ISBN: 99929-2-454-3

ИЗДАТЕЛЬСТВО “ГОРНАЯ КНИГА-МОНГОЛИЯ” СУДАЛГААНЫ ТАНХИМЫН НЭЭЛТИЙН АЖИЛЛАГАА

2010 оны 02 сарын 05-ны өдөр Шинжлэх Ухаан Технологийн төв номын санд ОХУ-ын “Мир горной книги” ассоциацийн “Горная книга” хэвлэлийн газрын Монгол дахь салбар Издательство “Горная книга-Монголия” судалгааны танхимын нээлтийн ажиллагаа болж өндөрлөлөө. Нээлтийн ажиллагаанд ШУТИС-ийн ректор проф. Б.Дамдинсүрэн, Монгол Улсын анхны ерөнхийлөгч, Издательство “Горная книга-Монголия” салбарын ерөнхийлөгч проф. П.Очирбат, Монголын уламжлалын академийн тэргүүн, Шинжлэх Ухаан амьдрал сэтгүүлийн ерөнхий нарийн бичгийн дарга проф. Л.Дашням,

санхүүжилтээр тохижуулсан бөгөөд уул уурхай, геологи, эрчим хүч, барилгын салбарын сургалт-судалгааны номыг профессор, багш нар захиалгаар авах, эрдэмтдийн бүтээлийг гадаадын хэвлэлд нийтлүүлэхэд гүүр болж ажилладаг юм. Уул уурхай, эрдэс баялгийг түшиглэн хөгжиж буй манай орны хувьд тус салбар байгуулагдсанаар дэлхийн жишигт хүрэх эхлэл болж байгааг нээлтэд оролцогчид онцолж байлаа. Түүнчлэн энэхүү салбараар уул уурхайн гадны томоохон байгууллагууд үйлчлүүлэх саналаа ирүүлээд байна. Дашрамд дурьдахад Издательство “Горная книга-Монголия”



ШУТИС-ийн проректорууд, Бүрэлдэхүүн сургуулийн захирлууд, Уул уурхайн хүрээлэнгийн захирал Б.Пүрэвтогтох, судлаачид, профессор багш нарын төлөөлөл оролцлоо. Уг танхимыг ШУТИС-ийн УУИС-ийн

салбарын ерөнхийлөгчөөр 2007 оноос эхлэн Монгол Улсын анхны ерөнхийлөгч проф. П.Очирбат, ерөнхий захирлаар Шинжлэх Ухаан Технологийн төв номын сангийн захирал проф. Ч.Гульнар ажиллаж байна.



ХААН БАНКНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ УНШЛАГЫН ТАНХИМЫН НЭЭЛТ

2010 оны 02 сарын 05-ны өдөр, Монголын багш нарын баярын өдрийг тохиолдуулан Шинжлэх Ухаан Технологийн төв номын санд “Хаан” банкны нэрэмжит эрдэм шинжилгээний уншлагын танхимын нээлтийн ёслол боллоо. Нээлтийг арга хэмжээнд Хаан банкны УБ хотын бизнес хариуцсан дэд захирал Ү.Наранцэцэг, Маркетингийн газрын захирал М.Чанцалмаа, Хаан банк сангийн захирал Ц.Оюунцэцэг, Хаан банкны соёлын төв өргөө салбарын захирал Ж.Ганбаатар, ШУТИС-ийн ректор проф. Б.Дамдинсүрэн, Монгол Улсын анхны ерөнхийлөгч, УУИС-ийн тэргүүлэх проф. П.Очирбат, Монголын уламжлалын академийн тэргүүн, Шинжлэх Ухаан амьдрал сэтгүүлийн ерөнхий нарийн бичгийн дарга проф.

сургуулийн захирлууд, Шинжлэх Ухааны салбарын судлаач эрдэмтэд, профессор багш нар хэвлэл мэдээллийн төлөөлөл оролцлоо.

Эрдэм шинжилгээний уншлагын танхимд нийт 11350 гаруй сургалт судалгааны бүтээлүүд, 2976 диссертаци, магистрын ажил, авторефератууд байна. Эрдэм шинжилгээний уншлагын танхим нь 170 м² талбай, 60 суудалтай, чөлөөт сонголтоор профессор багш, доктрант, магиструуд болон төгсөх курсийн оюутан, уншигчдад уншлагын танхимаар үйлчилгээ үзүүлдэг юм. Уг уншлагын танхимыг “Хаан” банкны санхүүжилтээр тохижуулан профессор, багш, судлаачдын судалгаа шинжилгээнийхээ ажлыг явуулахад таатай орчинг бүрдүүлэх үүднээс

Л.Дашням, ШУТИС-ийн сургалтын проректор проф. Я.Наранцэцэг, Эдийн засаг нийгмийн хөгжлийн проректор проф. Б.Даваасүрэн, Эрдэм шинжилгээ технологийн проректор проф. Х.Буяннэмэх, Гадаад харилцаа хамтын ажиллагааны проректор проф. Т.Батбаяр, Шинжлэх Ухаан, Технологийн төв номын сангийн захирал Ч.Гульнар, бүрэлдэхүүн

хамгийн сүүлийн үзүүлэлт бүхий Dell брэндийн дэлгэц, Athena брэндийн иж бүрэн компьютерууд, бар код сканер, дохиоллын хаалга болон бусад шаардлагатай стандартыг хангасан техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдээр тоноглож өгснөөрөө бусад оюутны уншлагын танхимаасаа ялгаатай юм.



“НОМЫН САН-ЦАХИМ ШИЙДЭЛ”



“Номын сан-Цахим шийдэл” сэдэвт сургалтыг ШУТИС-ийн Шинжлэх ухаан технологийн төв номын санд нэгдүгээр сарын 19-22 хооронд зохион байгуулж байна. Энэхүү сургалтанд Монгол Улсын их, дээд сургуулиуд болон нийтийн номын сангийн номын санч болон холбогдох албаны хүмүүс оролцож байгаа юм. Сургалтыг Шинжлэх ухаан технологийн төв номын сан, Монголын номын сангуудын консорциумаас номын санч, мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулах, электрон номын сангийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилтыг тодорхойлох, сургалтын материал-цахим шийдэл, гадаад электрон ном, сэтгүүл захиалах арга замууд, тогтмол хэвлэл электрон каталогт оруулах зорилготойгоор зохион байгуулж байна. “Электрон номын сангийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилт” гэсэн сэдвээр ШУТИС-ийн номын сангийн захирал Ч.Гульнар, Хүний хөгжил ба үйлчилгэний ёс зүй С.Төгс, Инженерийн боловсролд-Мэдээллийн технологи

(Е-номын сан) Мэдээлэл, технологийн төвийн захирал Р.Төрбат, Сэтгүүл захиалга цахим шийдэл” ШУТИС-ийн номын сангийн ахлах мэргэжилтэн Л.Гантулга, Хэвлэлийн технологи-ҮТДС-н багш Д.Дамдинсүрэн нар илтгэл тавьж хэлэлцүүлсэн. Сургалтанд хамрагдагсад өнөөгийн монгол улсын номын сангуудад тулгамдаж байгаа менежментийн асуудал, номын санчдын харилцаа, ёс зүй, хүнийг хөгжүүлэх талаар өөрийн мэдлэгийн цар хүрээг нэмэгдүүлж цаашдын судалгаа шинжилгээний ажил болон өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхээс гадна өөрийн сургуулийн номын сангийн нэг хувьтай болон зайлшгүй сэргээн засах хэрэгцээтэй номтой ажиллах, сэлбэн засах ажилбар явуулах, цахим асуудлыг шийдвэрлэх /электрон сэтгүүл захиалга, электрон каталогийн мэдээлэл солилцох/, бие даан өөрийн албан байгууллагын номын сангийн ажилтануудад сургалт зохион явуулах чадвар эзэмшинэ. Мөн сургалтанд оролцогчид ШУТИС-ийн дэлхийн их дээд сургуулиудын жишигт нийцсэн номын сантай танилцсан.

“НОМЫН САНГИЙН ПРОГРАМ ХАНГАМЖИЙН АШИГЛАЛТ” СЭДЭВТ СУРГАЛТ БОЛЛОО

ШУТТөв номын санд 2010 оны 03 сарын 03-06 хооронд бүрэлдэхүүн сургуулиуд болон орон нутгийн салбар сургуулийн номын санчдыг хамруулсан “Номын сангийн програм хангамжийн ашиглалт” сэдэвт сургалтыг зохион явууллаа. Сургалтанд Мэдээллийн технологи-номын сан сэдвээр е-



нээлттэй сургуулийн дэд захирал Р.Төрбат, номын сангийн Lib4U

програмын шинэ хувилбар, нэмэлт өөрчлөлт, уг програмын номын

сангийн үйлчилгээний явцад тулгарч буй асуудлуудын талаар Д.Ганхуяг

танилцуулж, үйлчилгээний явцад гарч буй асуудлаар санал солилцов. ШУТТөв номын сангийн бодлого, номын санчдын харилцаа, ёс зүй, үйлчилгээний ажилтны багаар

ажиллах чадвар,

цага

ашиг

талаар ШУТТөв

номын сангийн

захирал Ч.Гульнар мэдээлэл хийсэн. ШУТТөв номын сан нь их дээд сургуулийн номын сан мэдээллийн

ажилтнуудын хүрээнд номын сан-мэдээллийн технологийн сургалтыг хөтөлбөрийн дагуу тасралтгүй

явуулсаар байх болно.



ШУТТөв НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНУУДАД СУРГАЛТ ЯВУУЛЛАА

ШУТТөв номын сангаас захиргаанаас 01 сарын 27-ны өдөр номын сангийн үйлчлэгч нарт үйлчилгээний ажилтны баримтлах ёс зүй, цэвэрлэгээний бодисын норм, норматив, ажлын байрны хөдөлмөр хамгаалал, цэвэрлэгээ хийх журмын талаар сургалт явууллаа. Сургалтанд: “Үйлчилгээний ажилтны ёс зүй”



ШУТТөв номын сангийн захирал Ч.Гульнар, “Үйлчилгээний

ажилтнуудын хөдөлмөр хамгаалал” ШУТИС-ийн байр хариуцсан менежер Ж.Сэр-Од, “Өрөө

тасалгаануудад хийгдэх цэвэрлэгээ ба их цэвэрлэгээний журам” ШУТИС-ийн ЭМТ-ийн их эмч Л.Оюун, “Аж ахуйн хэрэглээний цэвэрлэгээний бодисыг хэрхэн хэрэглэх зааварчилгаа” номын санч П.Туяа, нар мэдээлэл хийлээ.



НОМ ХАНДИВЛАЛАА

АНУ-ын Азийн сангаас ҮТДС-ийн номын санд эдийн засаг, менежментийн чиглэлийн номыг хандивлалаа. Мөн Япон улсын



төслийн бус буцалтгүй тусламжийн хүрээнд БСШУЯ-наас 100 гаруй нэр

төрлийн номыг бэлэглэсэн нь оюутан суралцагчдын мэдлэг боловсрол, танин мэдэхүйг хөгжүүлэхэд тус дэм болж байна. Эдгээр номуудаар 2010 оны 03-р сарын 24, 25 нд номын үзэсгэлэн зохион байгуулж, уншигчдын хүртээл болголоо.



ДЭЛХИЙН ТОМООХОН НОМЫН САНГУУД

Оросын үндэсний номын сан

Оросын үндэсний номын сан бол Зүүн Европын хамгийн эртний номын сангуудын нэг юм. Энэ номын сан Санкт-Петербург хотод байрладаг. Энд Оросын их зохиолчдын ном бүтээл, орос хэлээр орчуулсан гадаадын ном зохиолууд хадгалагдаж байгаа. Мөн гадаадын шинжлэх ухаан, техник,



технологи, уран зохиолын олон мянган ном төрөлх хэлээрээ хадгалагдаж байна. Оросын үндэсний номын сан байгуулах шийдвэрийг 1795 оны 5 сарын 16-нд Оросын II-р Екатерина хатан хааны зарлигаар байгуулсан. Энэ номын сан нь ном хэвлэл хадгалаад зогсохгүй, хүмүүсийг соён гэгээрүүлэх эх булаг болох ёстой байлаа. Орост хэвлэгдсэн, мөн хилийн чанадад Орос хэлээр гарсан бүх номыг, гадаад хэлээр хэвдэгдсэн оросын тухай бүх номыг цуглуулж хадгалах зорилт тавьжээ. Хатан хаан Екатерина номын сангийн барилгын ажлын гүйцэтгэлд биечлэн хяналт тавьж, номын сангийн фонд үүсгэх ажилд ч гар бие оролцжээ. Ингээд 1714 оны 1 сарын 2-нд номын сангийн

нээлт болжээ. Нийгмийн бүх давхаргын хүн энэ номын санд үйлчлүүлэх эрхтэй байжээ. 1917 онд энэ номын санг Оросын нийтийн номын сан гэж нэрлэх болж, 1932 онд нийтийн номын санг М.Е.Салтыкова-Щедрины нэрэмжит болгожээ. Дэлхийн II-р дайны үед ч номын сан ажилласаар байлаа. 1973 оны 2 сард ЗХУ-ын сайд нарын зөвлөлийн шийдвэрээр номын сангийн шинэ барилга барих тогтоол гарч 1992 оны 3 сарын 27-нд ОХУ-ын ерөнхийлөгчийн зарлигаар дахин Оросын үндэсний номын сан гэж



нэрлэгдэх болжээ. Энэ номын санд 33 сая ширхэг ном, сонин, сэтгүүл хадгалагдаж байна. Номын санд жилдээ 1,5 сая хүн үйлчлүүлдэг.

“Өнөөдөр” 2010.03.10. №057(3920)

Ч.Гульнар

Их, дээд сургуулийн нүүр царай номын сангаасаа харагддаг

Дэлхийн нэр хүндтэй их, дээд сургуулиудын чанар чансааг тэндхийн номын сангийн хүртээмж үйлчилгээгээр нь хэмждэг гэдэг. Бас дэлхийн алдартай номын өргөөнүүд хорин дөрвөн цагийн турш үүд нь нээлттэй байдаг тухай түүгээр орж үзсэн манай эрдэмтэн мэргэд ярьдаг юм билээ. Манайд ч нэгэн үе номоор амьсгалж байсан. Цаг үе нийгмээ дагаад номноос хөндийрч байсан үе ард хоцорч эдүгээ ном хэвлэлийн газар олширч, чанар өнгө үзэмжтэй ном бүтээн туурвигчдын тоо ч эрс өсчээ. Түүнчлэн чихэнд чимэгтэй нэг мэдээ сонсогдсон нь ШУТИС дэлхийн хэмжээний гэж болох номын өргөөтэй болсон явдал юм. Тус номын сан орчин үеийн дотоод сүлжээгээр иж бүрэн тоноглогдсон, оюутнууд нь сурах бичгээр дутагдахгүйгээс гадна хичээлдээ бэлтгэх сургалтын хамгийн тохилог орчинтой болж багш, оюутан гэлтгүй хүссэн бүхний судалгааны төв болж чаджээ гэж багш, оюутнууд баяртай байна. Бид ШУТИС-ийн шинжлэх ухаан, технологийн төв номын сангийн захирал, доктор, профессор Ч.Гульнартай уулзаж номын сангийн үйл ажиллагааны талаар ярилцлаа.



- **Номын сангийн шинэ цогцолборын онцлог хийгээд үйлчилгээний талаар та юу хэлэх вэ?**

- Манай сургууль соёлын салбарт анхных гэж хэлж болох долоон давхар номын өргөөг өнгөрсөн оны 10 сард сургуулийнхаа 50 жилийн

ойн өмнө ашиглалтанд орууллаа. Номын санд зөвхөн оюутнууд бус профессор багш нарын сургалт, судалгааны орчин бий болгох, мэдээллийг орон зай хамааралгүйгээр цаг алдалгүй хүргэх, номын санч, мэдээллийн ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилттой

Мэдээлэл

ажиллаж байна. Номын сан маань сүүлийн үеийн дохиолол хамгаалалтын систем, орчин үеийн мэдээллийн технологи, утасгүй интэрнетийн /wireless/ орчин, каноны үйлчилгээ, номын хадгалалт, хамгаалалт, тоног төхөөрөмж гээд бүгд стандартын шаардлагыг бүрэн хангасан цогцолбор л доо. Хуучин номын сан 10 орчим нэгжээр 450 гаруй суудалтай байсан бол одоо 25 нэгжтэй 900 гаруй суудалтай болж үйлчилгээний хүрээ 2 дахин нэмэгдсэн. Өдөрт дунджаар 1500-2000 гаруй оюутанд үйлчилдэг байсан бол одоо 5500-6000 гаруй оюутанд үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс гадна техник, технологийн чиглэлийн төрийн болон хувийн хэвшлийнхэн уншлагын танхим, номын фонд эрдэмтдийн бүтээлээр үйлчлүүлж байна. Уншигчдын тоо өсч бидний үйл ажиллагааны цар хүрээ улам өргөжиж байгаа. Цаашдаа ШУТИС Монгол улсын шинжлэх ухаан технологийн мэдээллийн орчин бий болгох зорилготой. Гадаад харилцаагаа өргөжүүлэн ном солилцоо, гадаадын томоохон номын санд орох эрх авах, Е-уншлага, гадаад хэлний дижитал сургалтын танхим, жижиг хэвлэлийн газартай болно.

- **Гадаад харилцаагаа өргөжүүлэх тухай та ярилаа. Гадаад дотоодын байгууллагууд их ивээн тэтгэдэг гэсэн.**

- Тийм шүү. Монголд анх удаа дэлхийн 40 гаруй улсад салбартай “Русский мир” төв манай номын санд салбараа нээлээ. Мөн ОХУ-ын “Горная книга” ассоциаци 2007 онд салбараа нээсэн нь энэ салбарын оюутан багш судлаачдын талархлыг их хүлээж байна. Салбарын ерөнхийлөгчөөр нь Монгол улсын анхны ерөнхийлөгч, УУИС-ийн тэргүүлэх профессор П.Очирбат гуай ажилладаг. Техник-

технологийн орос номын үзэсгэлэнг зохион байгууллаа. Цаашдаа профессор багш нарын захиалгаар нэн түрүүнд шаардлагатай Е-номын үзэсгэлэн зохион байгуулах бодолтой байгаа. Бас ШУТИС-тай хамтран ажилладаг дотоодын байгууллагууд бидний ажилд их тусалдаг. ХААН, Голомт банк, Ньюком групп өөрийн нэрэмжит уншлагын танхимыг өөрсдийн хөрөнгөөр тохижуулсан. ШУТИС-ийн үе үеийн төгсөгчид болон багш, оюутан, ажилтнууд 79 сая төгрөгний хандив 100 гаруй мянган төгрөгний ном, сурах бичгийн дээжээ бэлэглэсэн. Ер нь манай номын сангийн хангамж эрс сайжирсан. Гэхдээ номын фонд бүрдүүлэхдээ тоонд бус чанарт их анхаардаг. Номын санчдын ажиллах орчин өөрчлөгдөж үйлчилгээ түргэн шуурхай болсноор оюутнууд номын санд суух нь ихэсч идэвх ч их сайжирсан гэж боддог.

- **Таныг монголын номын сангуудын консорциумын тэргүүн гэж сонссон?**

- Консорциум бүх төрлийн номын сан, мэдээллийн төвүүдийн хамтын үйл ажиллагааг дэмжиж сургалт зохион байгуулах, номын сангийн хөгжлийн стратеги боловсруулахад хувь нэмэр оруулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бус байгууллага. Номын санг автоматжуулах, мэдлэг, мэдээлэл солилцох, хамтарч ажиллах электрон мэдээлэл ашиглах боломжийг нэмэгдүүлэх, номын санчдыг чадавхжуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Саяхан 18 их дээд сургуулиудын 60 гаруй мэдээллийн ажилтан, номын санчдад зориулан “Номын сан-цахим шийдэл” сэдвээр 30 цагийн сургалт зохион явуулсан нь их үр дүнтэй боллоо.

- **Эцэст нь Та өөрийгөө танилцуулна уу?**

- Би 1979 онд Эрхүүгийн Багшийн их сургуулийг төгсөөд одоог хүртэл энэ сургуульдаа ажиллаж байна. Эрдэнэтийн технологийн сургуулийг байгуулалцаж дэд захирлаар нь

Мэдээлэл

ажиллаж байлаа. Манай аав Сүхбаатар, Баянзүрх дүүрэгт олон жил даргаар нь ажилласан. Товчхондоо ийм шив дээ.

“Өнөөдөр” 03 сарын 10. №057(3920)

СОЛОНГОСЫН ЧОНБУКЫН ИХ СУРГУУЛИЙН УРИЛГААР ДИЖИТАЛ НОМЫН САНТАЙ ТАНИЛЦЛАА

2010 оны 3-р сарын 23-28-ны хооронд Солонгосын Чонбукын номын сангийн урилгаар ШУТТНС-ийн захирал Ч.Гульнар, Мэдээлэл холбоо технологийн сургуулийн тэргүүлэх



хөрөнгө оруулалтаар “Солонгосын төв” байгуулах, номын санчдыг мэргэжил дээшлүүлэх, сургах асуудалд 2 тал тохиролцож, ШУТИС, Чонбукын их сургуулийн номын сангийн бүтэц, е-номын сангийн хөгжил, цаашдын зорилтын талаар илтгэл хэлэлцүүлээ.

профессор Б.Сүхбаатар, ШУТТНС-ийн ахлах номын санч О.Ариунжаргал нар ажиллаад ирлээ.

Томилолтын хугацаанд Чонбукын номын сангийн дотоод зохион байгуулалт, online хэлбэрээр номын захиалга хийх, e-үйлчилгээ, ном хадгалалт, хамгаалалттай танилцаж тус сургуулийн номын санд орох эрх авсан. Мөн ШУТТНС-д Чонбукын сургуулийн

Дашрамд дурьдахад уг сургуульд 150 гаруй оюутан бакалавр, магистр, докторын сургалтанд суралцдаг бөгөөд ШУТИС-аас суралцаж буй багш, оюутнуудын уулзалт болсон байна.



ЗААВАЛ УНШИХ 100 НОМЫН ЖАГСААЛТ

Монголын Лектор төвөөс санаачлан “Залуу Манлайлал-4” хөтөлбөрийн хүрээнд залуусын унших 100 номыг нэрлэлээ. Ном уншдаг залуу хүн цөөрсөн учраас тус төвийнхөн заавал унших 100 ном аяныг зохион байгуулж байна. Заавал унших 100 номонд хүний хөгжил, шинжлэх ухаан танин мэдэхүй, амьдрах ухаан, эрүүл мэнд, улс төр, эдийн засаг, түүх, уран зохиол, урлаг гоо зүй, философи сэтгэлгээ, гадаад хэл, компьютер гэсэн салбарын шилдэг номууд оржээ. Тодруулбал Жим Коллинзийн “Сайнаас агууд дэвшихүй”, Стивен Ковейн “Бүтээмж өндөртэй хүний 7-8 дадал”, Габриель Гарсиа Маркесийн “Зуун жилийн ганцаардал” номуудыг заавал уншсан байх ёстой юм байна.

ШИНЖЛЭХ УХААН, ТАНИН МЭДЭХҮЙ

Цаг хугацааны товч түүх / Стивен Хоункинг
Life and Energy / Isaac Asimov
On the origin of the species by means of natural selection / Charles Darwin/
Neuromancer / William Gibson/
King Solomon's ring / Konrad Lorenz/
Сэтгэл зүрхээ дага / Эндрю Корниш/
Ирээдүйд... Нэвтрэхүй / Эдвард Корниш/
Сэтгэхүйн цар хүрээний гайхамшиг / Дэйвид Жонзел Шварц/
Хүн бичнээс үүсээгүй / Э.Мулдашив/
Гайхамшигт нүд / Дорлинг Киндерслэй/
Оршихуйн гүн ухаан /Д.Баяндалай/
Дори идэр дүүдээ хандах нь /Б.Баабар/

ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ

How to Think about great ideas /Mortimer J.Adler/
Бүтээмж өндөртэй хүний 7 дадал /Стивен Ковай/
8 дахь дадал /Стивен Ковай/
Сайнаас агууд дэвшихүй /Жим Коллинз/
Биеийн хөдөлгөөний хэл /Аллан Пиз/
Нөхдөө өөртөө татаж бусдад нөлөөлөх ёсон /Дэйл Карнеги/
Олны өмнө хэрхэн амжилттай илтгэл тавих вэ? /Дэйл Карнеги/
Ажил хэргийн гурвалжин 1,2 /Ц.Баатархүү/
Нууц /Ронда Бёрн/
Алсын хараа / Л.Оюун-Эрдэнэ/
Өөрийгөө хөгжүүлэе ! /Эмос клуб/

ФИЛОСОФИ, СЭТГЭЛГЭЭ

Нээлттэй нийгэм ба түүний дайснууд / Карл Поппер/
Либертарианизм /Давид Боаз/
Utopia /Thomas More/
The evolution of society /Herbert Spencer/
Өрнийн мэргэн ухаан /Бертран Рассел/

The logic of science discovery /Karl R.Popper/
Их гурвалжин /Ч.Эрдэнэ/
2*2=6 суут жаран сэтгэгч /Г.Аюурзана/

ТҮҮХ

Rites of Spring /Modris Eksteins/
The women's history of the world /Rosalind Miles/
Түүхийн төгсгөл ба сүүлчийн хүн /Францис Факуяма/
The world's religions /Huston Smith/
Монголын нууц товчоо /Ц.Дамдинсүрэн/
Түүх судлал/ Арнольд Тойнби/
XX зууны Монголчууд /Роберт Рүпэн/
Судрын чуулган /Рашид Ад-Дин/
Хөх судар /Инжинаш/
Дэлхийг байлдан дагуулагчийн түүх /Жүвэйни/
Түүхэнд хамгийн их нөлөө үзүүлсэн 100 хүн /Майкл Хаарт/
Монголчууд нүүдэл суудал / Б.Баабар/

УРАН ЗОХИОЛ, ЯРУУ НАЙРАГ

Гэсэр, Жангар /Ардын аман зохиол/
Дайн ба Энх /Л.Толстой/
Евгений Онегин /А.Пушкин/
Зуун жилийн ганцаардал /Габриель Гарсиа Маркес/
Ах дүү Карамазовынхан /Ф.Достоевский/
Зохиол бүтээлүүд /Д.Равжаа/
Заан залуудай /Б.Ренчин/
Сүмтэй будрын чулуу /Р.Чойном/
Хорвоотой танилцсан түүх /Л.Түдэв/
Хос уянга /Б.Лхагвасүрэн/
Сонгомол яруу найраг /Г.Аюурзана, Л.Өлзийтөгс/
Сонгомол өгүүллэг /Г.Аюурзана, Л.Өлзийтөгс/



Шинжлэх Ухаан Технологийн төв номын
сангийн электрон каталогийн хаяг:
<http://opac.must.edu.mn>



Шинжлэх Ухаан Технологийн төв номын санд ирсэн сэтгүүлийн шинэ дугаарууд



Эрхэм уншигч та:
Шинэ номын мэдээ, мэдээллийн талаарх санал хүсэлтээ
Шинжлэх Ухаан Технологийн төв номын сангийн
library@must.edu.mn хаягаар ирүүлнэ үү.
Шинжлэх Ухаан Технологийн төв номын сан